



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ КОМПАНИ

2019 оны 02 сарын 18-ны өдөр

Дугаар. 1.

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Ногдол ашиг
хуваарилах тухай


Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 02 сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн 2018 оны ногдол ашгийг татвар төлсний дараахь цэвэр ангиас хуваарилж олгосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 500 төгрөгийн ногдол ашиг олгохоор тогтоосугай.
3. Ногдол ашгийг 2019 оны 04 сарын 11-ний өдрөөс эхлэн компани дээрээс олгосугай.
4. Дээрх хугацаанд аваагүй ногдол ашгийн үлдэгдлийг хувьцаа эзэмшигчдийн ҮЦГХТ ХХК-д байрлах дансанд байршуулахаар шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу ногдол ашиг олгохыг Гүйцэтгэх захирал Д. Ганцэцэг, ерөнхий нягтлан бодогч С. Дашдулам нарт үүрэг болгосугай.



Тунгалаг

/ Т. ТУНГАЛАГ /



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ КОМПАНИ

2019 оны 02 сарын 18-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1-р зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 02-р сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг туслас үндэслэн

"Техник импорт" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 сарын 18-ны өдрийн хурлаар ТОГТООХ нь:

1. Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2019 оны 04 сарын 11-ний өдрийн 15 цагт Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125, Техник импорт ХК-ийн "Хурлын танхим"-д хуралдуулсугай.
2. Техник импорт ХК-ийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт
 2. Компанийн 2018 оны ажлын тайлан
 3. 2019 оны ажлын төлөвлөгөө
 4. ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс 2019 оны 03 сарын 11-ний өдөр (бүртгэх өдөр)-өөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг үндэслэн тогтоосугай.
4. "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.5-д заасны дагуу бүртгэлийн өдрийг 2019 оны 03 сарын 11-ний өдрөөр тасалбар болгохоор тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2019 оны 04 сарын 11-ний өдөр хуралдуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 3.2-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх, хуралтай холбогдох асуудлыг зохих журмын дагуу эрхлэн явуулахыг Хурал зохион байгуулах комиссын дарга О. Бүжиннямд даалгахаар тогтоосугай.
7. Компанийн тухай хуулийн 59.10-д заасны дагуу 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Дашдондог овогтой Ганцэцэгийг томилсугай.



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ КОМПАНИ

201...оны...сарын...-ны өдөр

Дугаар....

Улаанбаатар хот

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй төмнөсугай.
Тооллогын комиссын дарга Б. Лхамсүрэн
Тооллогын комиссын гишүүн О. Оюунсүрэн
9. Компанийн тухай хуулийн 67.3, 67.4-т заасан эрх, үүргийг хэрэгжүүлж санал хураалтын дүнг үнэн, зөв гаргаж хариуцлагатай ажиллахыг Тооллогын комисст үүрэг болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт1-т заасан бичиг баримттай танилцах бүрэн эрхтэй болохыг дурьдсугай.
11. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ны агуулгыг Хавсралт2, Хавсралт3-т зааснаар баталсугай.
12. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар болон хурлын материал хүлээн авсан тухай мэдэгдлийн агуулгыг Хавсралт4-т зааснаар баталсугай.
13. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын итгэмжлэлийн агуулгыг Хавсралт5-т зааснаар баталсугай.
14. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар болон хурлын материал хүлээн авсан тухай мэдэгдлийн агуулгыг Хавсралт5-т зааснаар баталсугай.
15. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2019 оны 04 сарын 10-ны өдрийн 18 цагаар тасалбар болгосугай.
16. Хурал хуралдуулах шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор Техник импортХК-ийн "Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл"-ийг холбогдох маягтын дагуу СЗХ, Монголын Хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисст заалгахаар тогтоосугай.



/ Т. ТУНГАЛАГ /



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ КОМПАНИ

2019 оны 02 сарын 18-ны өдөр

Дугаар 3...

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хамтарсан компани
байгуулах тухай

Техник импорт ХК-ийн Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналыг үндэслэн

Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 02 сарын 18-ны өдрийн
хурлаас ТОГТООХ нь:

1. Япон улсын Нийгата мужийн НийгатаКубота ХК-тай хамтран 2 талын хамтарсан хөрөнгө оруулалттай “Эм Жэй Агритех” ХХК-ийг байгуулахыг Техник импорт ХК-д зөвшөөрсүгэй.
2. “Эм Жэй Агритех” ХХК-ийг улсын бүртгэлийн газар бүртгүүлэх, шаардлагатай холбогдох бичиг баримт авах, Хамтарсан компанид оруулах хөрөнгийн хэмжээг зохих журмын дагуу бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал Д. Ганцэцэгт үүрэг болгосугай.



/ Т. ТУНГАЛАГ /